

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/132/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдөр	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2. Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2023.02.24 № 2/102

танай _____-ны № _____-т

**БАЯНЛИГ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ЦЭДЭНДОРЖ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2022 онд 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн 11 арга хэмжээний зардалд 1,744,784.1 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,683,374.8 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт 19,355.9 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 38,067.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Аудитын гол асуудал

Дээд шатны байгууллагын шийдвэрээр 2022 оноос ерөнхий боловсролын сургуулиуд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжиж, багшийн цахим хэрэглээ, эрүүл мэндийг дэмжих зардлуудыг төсвөөс олгосон, БШУЯ-наас үр дүнд суурилсан гүйцэтгэлийн үнэлгээгээр 16 багш 1-2 дугаар түвшинд үнэлэгдсэн байна.

Малын нас дэвшилтийн орлогыг санхүүгийн тайланд тусгах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зэрэг зөвлөмжийг өгсөн нь бидний тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилго 6 зорилтын хүрээнд 70 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган хэрэгжүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Баянлиг сумын Засаг дарга, аймгийн БШУГ-аас 95.3 хувиар үнэлсэн байна.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	111,940,348.29	186,951,584.67
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	38,067,514.86
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	38,067,514.86
3121	Төгрөг	00.00	38,067,514.86
31211	Төрийн сангийн харилцах	00.00	38,067,514.86
33	АВЛАГА	5,449,398.72	23,701,800.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	549,398.72	00.00
335	Бусад авлага	4,900,000.00	23,701,800.00
3351	Байгууллагаас авах авлага	4,900,000.00	23,701,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	106,490,949.57	125,182,269.81
351	Түүхий эд материал	19,031,096.54	22,855,416.78
35110	Тусгай зориулалттай материал	13,682,856.54	21,521,016.78
35130	Эм боох материал	5,348,240.00	1,334,400.00
354	Хангамжийн материал	86,409,853.03	101,276,853.03
35410	Бичиг хэргийн материал	559,110.00	984,110.00
35420	Аж ахуйн материал	85,551,743.03	100,292,743.03
35470	Бусад хангамжийн материал	299,000.00	00.00
35600	Мал амьтад	1,050,000.00	1,050,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,579,066,028.03	5,267,553,789.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,579,066,028.03	5,267,553,789.63
392	Биет хөрөнгө	4,538,936,028.03	5,219,583,789.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,983,045,331.02	5,714,792,117.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	-645,070,348.32	-764,573,646.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,500,000.00	15,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,500,000.00	-15,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	307,727,907.14	408,304,017.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	-225,594,056.32	-251,307,539.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	223,038,411.20	236,855,411.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-130,727,269.69	-151,002,622.91
39217	Ном	26,516,053.00	26,516,053.00
393	Биет бус хөрөнгө	40,130,000.00	47,970,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	40,130,000.00	47,970,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,691,006,376.32	5,454,505,374.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	460,667.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	460,667.00	00.00
413	Өглөг	460,667.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	460,667.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,690,545,709.32	5,454,505,374.30
51	Засгийн газрын хувь оролцоо	4,690,545,709.32	5,454,505,374.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	514,828,217.20	514,828,217.20
51101	Өмч: - төрийн	514,828,217.20	514,828,217.20
512	Хуримтлагдсан үр дүн	3,524,762,028.43	4,288,721,693.41
51210	Өмнөх үеийн үр дүн	3,524,762,028.43	3,524,762,028.43
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	763,959,664.98
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	650,955,463.69	650,955,463.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,691,006,376.32	5,454,505,374.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,367,851,415.68	2,688,250,559.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,743,247.00	911,509,425.24
120	Нийтлэг татварын бус орлого	2,743,247.00	911,509,425.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	904,899,465.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,985,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,471,825.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,365,108,168.68	367,018,834.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,105,561,900.00	1,409,722,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,520,913.00	43,189,134.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,185,770.00	43,189,134.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,335,143.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	210,025,355.68	323,829,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	210,025,355.68	323,829,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,556,154,495.83	1,924,290,894.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,556,154,495.83	1,924,290,894.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,471,275,433.17	1,791,887,566.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	853,258,116.63	1,021,125,046.15
210101	Үндсэн цалин	853,258,116.63	703,396,458.15
210102	Нэмэгдэл	00.00	245,028,512.00
210104	Урамшуулал	00.00	36,915,741.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	35,784,335.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,419,095.89	128,513,434.60
210201	Тэтгэврийн даатгал	110,419,095.89	86,814,277.92
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	9,668,739.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	7,704,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,926,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	22,399,917.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200,025,355.68	260,588,332.79
210301	Гэрэл, цахилгаан	5,306,105.68	10,299,832.79
210302	Түлш, халаалт	194,719,250.00	250,288,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,001,525.10	12,465,274.20
210401	Бичиг хэрэг	2,665,600.00	298,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,389,525.10	6,180,074.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,796,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	960,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,400.00	5,747,200.00
2105	Нормативт зардал	31,020,672.00	95,011,490.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,222,347.00	4,244,240.00
210502	Хоол, хүнс	25,600,325.00	90,767,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,198,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,168,500.00	3,567,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	210,000.00	00.00
210604	Урсгал засвар	14,958,500.00	3,567,000.00
2107	Томилолт, зочны зардал	682,000.00	1,370,200.00
210702	Дотоод албан томилолт	682,000.00	1,370,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,383,100.00	8,816,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,453,100.00	4,271,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	480,000.00	4,045,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	246,317,067.87	260,430,288.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,245,850.00	13,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,103,000.00	10,154,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	236,968,217.87	237,176,288.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,879,062.66	132,403,328.12

2132	Бусад урсгал шилжүүлэг	68,299,270.00	113,047,434.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,345,500.00	69,858,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,185,770.00	43,189,134.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,043.00	19,355,894.12
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,540,749.66	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,540,749.66	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-188,303,080.15	763,959,664.98
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	508,062.90	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	508,062.90	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-508,062.90	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-188,811,143.05	763,959,664.98

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,365,108,168.68	1,784,287,390.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	7,546,256.72
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	7,546,256.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	7,546,256.72
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	4,074,431.72
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,471,825.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,365,108,168.68	1,776,741,134.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,105,561,900.00	1,409,722,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,520,913.00	43,189,134.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,185,770.00	43,189,134.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,335,143.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	210,025,355.68	323,829,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	210,025,355.68	323,829,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,334,269,168.68	1,717,997,765.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,334,269,168.68	1,717,997,765.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,249,390,106.02	1,568,907,237.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	852,454,200.24	1,021,125,046.15
210101	Үндсэн цалин	635,524,657.05	703,396,458.15
210102	Нэмэгдэл	162,486,785.00	245,028,512.00
210104	Урамшуулал	54,442,758.19	36,915,741.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	35,784,335.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,393,200.00	128,513,434.60
210201	Тэтгэврийн даатгал	80,429,900.00	86,814,277.92
210202	Тэтгэмжийн даатгал	7,490,900.00	9,668,739.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,992,700.00	7,704,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,498,100.00	1,926,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,981,600.00	22,399,917.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200,025,355.68	260,588,332.79
210301	Гэрэл, цахилгаан	5,306,105.68	10,299,832.79
210302	Түлш, халаалт	194,719,250.00	250,288,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,157,625.10	00.00
210401	Бичиг хэрэг	1,411,700.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,389,525.10	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,036,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	960,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,360,400.00	00.00
2105	Нормативт зардал	32,644,125.00	74,080,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,159,800.00	00.00

210502	Хоол, хүнс	25,600,325.00	74,080,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,884,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,220,300.00	3,567,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	361,800.00	00.00
210604	Урсгал засвар	19,858,500.00	3,567,000.00
2107	Томилолт, зочны зардал	682,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	682,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,640,100.00	14,328,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,950,100.00	3,985,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	10,342,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,173,200.00	66,705,174.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,213,300.00	53,130,474.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,959,900.00	13,574,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,879,062.66	149,090,528.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,299,270.00	129,734,634.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,345,500.00	86,545,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,185,770.00	43,189,134.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	39,043.00	19,355,894.12
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,043.00	19,355,894.12
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,540,749.66	0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,540,749.66	0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	30,839,000.00	66,289,624.86
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	30,839,000.00	28,222,110.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,839,000.00	28,222,110.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,839,000.00	28,222,110.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	30,839,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	28,222,110.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-30,839,000.00	-28,222,110.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	38,067,514.86
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	38,067,514.86

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	474,698,217.20	00.00	5,094,471,298.76	5,569,169,515.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	474,698,217.20	00.00	5,094,471,298.76	5,569,169,515.96
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	40,130,000.00	00.00	-1,028,298,023.19	-988,168,023.19
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	514,828,217.20	650,955,463.69	3,524,762,028.43	4,690,545,709.32
D01	2022 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	514,828,217.20	650,955,463.69	3,524,762,028.43	4,690,545,709.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	514,828,217.20	650,955,463.69	3,524,762,028.43	4,690,545,709.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн				0.00
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	514,828,217.20	650,955,463.69	4,288,721,693.41	5,454,505,374.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,744,784,100.00	1,683,674,847.74	61,109,252.26	96.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,744,784,100.00	1,683,674,847.74	61,109,252.26	96.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,653,723,000.00	1,597,129,347.74	56,593,652.26	96.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,050,159,700.00	1,021,125,046.15	29,034,653.85	97.24
210101	Үндсэн цалин	758,751,900.00	703,396,458.15	55,355,441.85	92.70
210102	Нэмэгдэл	232,595,400.00	245,028,512.00	-12,433,112.00	105.35
210104	Урамшуулал	22,424,800.00	36,915,741.00	-14,490,941.00	164.62
210105	Гэрээт ажлын хөлс	36,387,600.00	35,784,335.00	603,265.00	98.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,590,700.00	128,513,434.60	3,077,265.40	97.66
210201	Тэтгэврийн даатгал	89,481,800.00	86,814,277.92	2,667,522.08	97.02
210202	Тэтгэмжийн даатгал	10,527,300.00	9,668,739.00	858,561.00	91.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,421,700.00	7,704,300.00	717,400.00	91.48
210204	Ажилгүйдлийн даатгал	2,105,400.00	1,926,200.00	179,200.00	91.49
210205	Эрүүл мэндийн даатгал	21,054,500.00	22,399,917.68	-1,345,417.68	106.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	279,005,700.00	260,588,332.79	18,417,367.21	93.40
210301	Гэрэл, цахилгаан	9,997,200.00	10,299,832.79	-302,632.79	103.03
210302	Түлш, халаалт	267,228,500.00	250,288,500.00	16,940,000.00	93.66
210303	Цэвэр, бохир ус	1,780,000.00	00.00	1,780,000.00	00.00
2105	Нормативт зардал	75,530,300.00	74,080,050.00	1,450,250.00	98.08
210502	Хоол, хүнс	75,530,300.00	74,080,050.00	1,450,250.00	98.08
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,567,100.00	3,567,000.00	100.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,325,300.00	14,328,200.00	3,997,100.00	78.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,760,300.00	3,985,700.00	3,774,600.00	51.36
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,565,000.00	10,342,500.00	222,500.00	97.89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,544,200.00	94,927,284.20	616,915.80	99.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	79,696,700.00	79,083,584.20	613,115.80	99.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,847,500.00	15,843,700.00	3,800.00	99.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,061,100.00	86,545,500.00	4,515,600.00	95.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,061,100.00	86,545,500.00	4,515,600.00	95.04
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	91,061,100.00	86,545,500.00	4,515,600.00	95.04
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,744,784,100.00	1,721,742,362.60	23,041,737.40	98.68
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	323,829,700.00	304,473,805.88	19,355,894.12	94.02
132001	Орон нутгийн төсвөөс	323,829,700.00	304,473,805.88	19,355,894.12	94.02
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,232,100.00	7,546,256.72	3,685,843.28	67.18
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,760,300.00	4,074,431.72	3,685,868.28	52.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,471,800.00	3,471,825.00	-25.00	100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	38,067,514.86	-38,067,514.86	
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	800.00	800.00	00.00	100.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	800.00	800.00	00.00	100.00
630001	Төрийн өмчит ЕБС	800.00	800.00	00.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	72.00	72.00	00.00	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	55.00	55.00	00.00	100.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	01.00	01.00	00.00	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	01.00	01.00	00.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15.00	15.00	00.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,189,134.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43189134.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,189,134.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	43,189,134.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	43,189,134.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,189,134.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,189,134.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянлиг сумын ЕБС нь "Хүүхэд бүрийн нийгэм, сэтгэл зүй, эрүүл мэнд, танин мэдэхүйн хөгжилд дэмжлэг үзүүлж, тэдний ялгаатай байдал, сурах хэв маягийг харгалзан амжилттай сурах тэгш боломж бүрдүүлэх" эрхэм зорилготой тус сургууль нь 2022 онд 6 зорилт дэвшүүлж, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захиргаа аж ахуй, Нийгмийн ухаан, Байгалийн ухаан, Бага ангийн заах аргын нэгдэл гэсэн бүтэц зохион байгуулалттай 72 орон тоотой, 800 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал С.Цэдэндорж, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Нарангэрэл нар зурж, нярваар А.Батзаяа нар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдсөн;
- Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчилснийг мөрдсөн;
- Засгийн газрын 2022 оны 107, 192 дугаар тогтоолоор цалингийн шатлал өөрчлөгдсөн;
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн;

- БШУС-ын 2022.05.12-ны өдрийн 170 дугаар тушаалын дагуу 4 ажлын хэсгийг байгуулсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 760,027.2 мянган төгрөгөөр буюу 16.2 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт А	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	38,067.51	38,067.51
Авлага	5,449.40	20,230.00	14,780.60
Бараа материал	106,490.95	125,182.27	18,691.32
Үндсэн хөрөнгө	5,595,957.70	6,449,937.60	853,979.90
Хуримтлагдсан элэгдэл	(1,016,891.67)	(1,182,383.81)	(165,492.1)
Нийт хөрөнгө	4,691,006.38	5,451,033.57	760,027.20
Өр төлбөр	460.67	-	(460.67)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,690,545.71	5,451,033.57	760,487.86
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,691,006.38	5,451,033.57	760,027.19

Эх сурвалж: Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд хүүхэд өдрийн гүйцэтгэлээс шалтгаалж үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны зардал, цалингийн зардал, халаалтын зардлыг илүү төлөвлөснөөс цалингийн зардал хэмнэгдсэн, түрээсийн сурах бичгийн орлогын төлөвлөгөөг илүү төлөвлөж хуваарилснаас 3,774.6 мянган төгрөгийг зарцуулаагүй зэргээс шалтгаалж, оны эцэст харилцах дансанд 38,067.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Тус байгууллагын захирал “Саммит компьютер” ХХК-тай 2022.12.13-ны өдөр БХАБГСЕБС/002/001 дугаартай гэрээг байгуулж, нэг бүр нь 2,890.0 мянган төгрөгийн үнэ бүхий 7 ширхэг i5 зөөврийн компьютерыг худалдан авах гэрээг байгуулж, 2022.12.21-ний өдөр хөрөнгийн үнэнд 20,230.0 мянган төгрөгийг шилжүүлж, авлагаар бүртгэсэн, хөрөнгийг 2023 оны 02 дугаар сард хүлээн авсан байна.

Тайлант жилд хичээлийн хэрэглэгдэхүүн худалдан авснаар тусгай зориулалтын материал, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн гэрэл орлогод авснаар бараа материалын дүн өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

Төсвийн хөрөнгөөр 28,222.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, БСШУ-аас дижитал танхим бүрдүүлэхэд 69,968.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 6,267.0 мянга, эцэг эхчүүдийн 5,150.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандиваар авсан, сумын хуучин Соёлын барилгын 803,430.9 мянган төгрөгийн барилгыг шилжүүлэн авсан, хөл бөмбөгийн талбайн газрыг 7,840.0 мянган төгрөгөөр бүртгэсэн зэргээс шалтгаалж, үндсэн хөрөнгө өмнөх оноос нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 763,959.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 4,288,721.7 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 763,959.7 мянган төгрөгөөр нэмэгдэн цэвэр хөрөнгийн дүн 5,454,505.4 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 1,534,761.4 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 323,829.7 мянга, нийт 1,858,591.1 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжих зардлыг 293,768.2 мянган төгрөгөөр хасаж, 1,240,993.2 мянган төгрөгөөр баталсан нь цалин, томилолт, бичиг хэрэг, бусад зардлуудыг хасаж баталсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг дээд шатны байгууллагаас цалингийн шатлал нэмэгдсэнтэй холбоотой цалин, НДШ-ийн зардлыг 2022 оны 5 дугаар сард 91,351.8 мянга, 9 дүгээр сард 16,622.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Тайлант оны 11 дүгээр сард нөхөн хангалтын зардал, үдийн цай, дотуур байрны хоолны зардлыг 68,815.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,417,782.6 мянган төгрөгөөр баталж, оны

эцэст төсвийг 3,171.8 мянган төгрөгөөр хасаж 1,744,784.1 мянган төгрөгөөр баталж, үүнээс өөрийн орлогоор 7,760.3 мянган төгрөгийг оруулахаар төлөвлөжээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 1,409,722.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 1,371,654.7 мянган төгрөгийг зарцуулж, зардлын хэмнэлтийн 38,067.5 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 323,829.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 94.0 хувь буюу 304,473.8 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн санхүүжилтийн харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл 19,355.9 мянган төгрөгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/				
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	4,226.0	4,225.7	0.3	100.0	
2	80312 Сургалт семинар	2,113.0	2,045.5	67.5	96.8	
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	4,859.9	4,843.8	16.1	99.7	
4	81801 үдийн цай хөтөлбөр	91,061.1	86,545.5	4,515.6	95.0	
5	81806 Дотуур байрны үйлчилгээ	107,733.9	104,907.0	2,826.9	97.4	
6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	46,455.0	46,183.1	271.9	99.4	
7	81823 Боловсролын байгууллагын багш,	9,508.5	9,252.2	256.3	97.3	
8	81834 Боловсролын стандарт, сургалтын	1,052,413.1	1,033,770.5	18,642.6	98.2	
9	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	91,351.8	79,970.1	11,381.7	87.5	
10	81848 Сурах бичгийн түрээс	7,760.3	3,985.7	3,774.6	51.4	
11	83603 Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	3,471.8	3,471.8	-	100.0	
12	80112 Нийтлэг үйлчилгээ	323,829.7	304,473.8	19,355.9	94.0	
	ДҮН	1,744,784.1	1,683,674.7	61,109.4	96.5	

Эх сурвалж: Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 5 жилд нэг удаа олгох тэтгэмжийн санхүүжилтийн 43,189.1 мянган төгрөгийг сургуулийн захирлын тушаалаар 9 багшид олгосон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Боловсролын мэдээллийн технологийн төв" УТҮГ-аас суурилуулсан интернэтийг ашиглах, холбогдох шийдвэрийг үндэслэн, албан хаагчдын цалин хөлсийг үнэн зөв олгох, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст гэрээг нөхөн байршуулах сэргийлэх зэрэг зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.01.23-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлж, санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,420,954.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 21,314.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 14,920.0 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжүүлээгүйгээс аудитаар 6,300.1 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд 6,180.1 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 120.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,707,219.6 мянган төгрөгийн 53

гүйлгээ, зарлагын 421,666.3 мянган төгрөгийн 24 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 67,791.4 мянган төгрөгийн 4 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 43,430.6 мянган төгрөгийн 5 зарлагын гүйлгээ, байгууллагын даргын 2022 онд гаргасан 138,001.8 мянган төгрөгийн 8 тушаалыг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй орхигдуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг дутуу байршуулсан зөрчил өмнөх онд илэрч, менежментийн захидлаар зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлээгүйгээс 2022 онд зөрчил давтан илэрсэн тул албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг 2022 оны 12 дугаар сард гүйцэтгэж, аудитаар илэрсэн зөрчлийг сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга, байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нарт танилцуулсан, аудитаар илэрсэн зөрчлийн биелэлтийг аудитаар гаргуулж, хэрэгжилтийг тооцов.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, 2,100.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, менежментийн захидлаар үнийн дүнгүй 2 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	79.2	1	79.2	100%
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	2	0	2	0	50%
Нийт дүн	3	79.2	3	79.2	75%

Эх сурвалж: Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022.05.25-ны өдрийн 46 дугаар албан бичиг

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2022.05.25-ны өдөр 46 дугаар албан бичгээр ирүүлсэн, төлбөрийн актыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, харин шилэн дансны цахим хуудаст мэдээллийг байршуулах, хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах зөвлөмжийг бүрэн биелүүлээгүй, өмнөх жил гарсан зөрчил давтагдсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын туслах аж ахуйг хариуцсан малчин байхгүй, тэтгэвэрт гарсан байгаа тул дараагийн аудитаар мал аж ахуйн орлогыг тодруулан үзэх шаардлагатай.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд үнэ төлбөргүй олгосон үндсэн хөрөнгөтэй холбоотой зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй байна.

Засгийн газрын 2019 оны 450 дугаар "Хоолны зардлын норматив тогтоох тухай" тогтоолын 4-т "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх"-ыг БШУС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 оны 1, 2 дугаар саруудад бүрэн ажиллаагүй, хоолны ирцэд хяналт тавьснаар хүүхдийн хоолны зардал 1,450.2 мянга, үдийн цай хөтөлбөрийн зардал 4,415.6 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй, харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,471.8 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг залруулав. Үүнд:

Баянлиг сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал "Сураад" ХХК-тай 2022.12.14-ны өдөр 22/34 дугаар хамтын ажиллагааны гэрээ байгуулж, 2022.12.19-ний өдөр 3,471.8 мянган төгрөгийг шилжүүлсэн ба гэрээний 3.3-т "Сургалтыг 2023.02.01-2023.06.01-ний өдөр хүртэл зохион байгуулна" гэж заан, сургалтыг 2022 онд эхлүүлээгүй байхад тайлант жилийн зардлаар тайлагнасан тул санхүүгийн тайланд зардлыг бууруулж, авлагаар залруулав.

Аудитаар нийт 9,555.3 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрснээс, 2,325.2 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой үнийн дүнгүй 1 албан шаардлага хүргүүлж, 7,230.1 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг менежментийн захидлаар өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2,000.0 мянган төгрөгийн трактор тооллогоор дутагдсан байхад арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.3 дахь "Тооллогын комисс дараах үүрэгтэй: Агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах”, 72.5.1 дэх “Тооллогын комисс дараах эрхтэй: тооллого явуулахын өмнө эд хариуцагчдын хариуцаж байгаа бараа материалын үнэ бүхий зүйл, мөнгөн касс, агуулахыг лацдаж ломбодох болон харуул хамгаалалтын талаар илэрсэн дутагдлыг арилгах арга хэмжээ авахыг холбогдох хүмүүст шаардах” гэснийг зөрчсөн тул сургуулийн захирлаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант оны 9 дүгээр сард олгосон 205.1 мянган төгрөгийн шатахууны тайлан, зам явсан хуудас байхгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэснийг зөрчсөн тул сургуулийн нярваар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Байгууллагын даргын 2022.11.23-ны өдрийн Б/59 дүгээр тушаалаар 9 сургуулийн захирал, нягтлан бодогч нарт гар утасны зардалд 120.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: гар утасны зардал” гэснийг зөрчсөн тул нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Баянлиг сумын сургуулийн нягтлан бодогч таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 43,430.6 мянган төгрөгийн зарлагын 5 гүйлгээ, аж ахуйн нэгжтэй байгуулсан 328,005.8 мянган төгрөгийн 3 гэрээ, сургуулийн захирлын гаргасан 67,791.3 мянган төгрөгийн 4 тушаалыг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй, сар бүрийн санхүүжилтийг бөөн дүнгээр буруу мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн тул зөрчлийг арилган орхигдуулсан мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх албан шаардлагыг өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /Төрийн хэмнэлтийн тухай хууль/

Илрүүлэлт: Баянлиг сумын ерөнхий боловсролын сургууль тайлант онд тээвэр шатахууны зардалд 6,180.1 мянган төгрөгийг зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3 дахь “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

2. Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд оны эхэнд 1,050.0 мянган төгрөгийн 37 мал амьтан бүртгэлтэй, тайлант онд малын нас дэвшилтийн орлого, хөдөлгөөнийг бүртгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Туслах аж ахуйн тооцоо, нягтлан бодох бүртгэлийг хууль, тогтоомжид нийцүүлэн үнэн зөв бүртгэж тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан нягтлан бодогчид талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сургуулийн захирал "Сураад" ХХК-тай 2022.12.14-ны өдөр 22/34 дугаар хамтын ажиллагааны гэрээ байгуулж, 2022.12.19-ний өдөр 3,471.8 мянган төгрөгийг шилжүүлсэн ба гэрээний 3.3-т "Сургалтыг 2023.02.01-2023.06.01-ний өдөр хүртэл зохион байгуулна" гэж заан, сургалтыг 2022 онд эхлүүлээгүй байхад тайлант жилийн зардлаар тайлагнасан байна.	1	3,471.8					1	3,471.8				
Дүн	1	3,471.8	0	0	0	-	1	3,471.8	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2,000.0 мянган төгрөгийн трактор тооллогоор дутагдсан байна.	1	2,000.0	1	2,000.0								
Тайлант оны 9 дүгээр сард олгосон 205.1 мянган төгрөгийн шатахууны тайлан, зам явсан хуудас байхгүй.	1	205.2	1	205.2								
Оны эхэнд 2010 онд 8 ямаа, 2013 онд 14 хурга, 2015 онд 15 ишиг, нийт 1,050.0 мянган төгрөгийн 37 мал амьтан бүртгэлтэй, тайлант онд малын нас дэвшилтийн орлого, хөдөлгөөнийг бүртгээгүй байна.	1	1,050.0					1	1,050.0				
Дүн	3	3,255.2	2	2,205.2	0	-	1	1,050.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Сургуулийн нягтлан бодогч таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 43,430.6 мянган төгрөгийн зарлагын 5 гүйлгээ, аж ахуйн нэгжтэй байгуулсан 328,005.8 мянган төгрөгийн 3 гэрээ, сургуулийн захирлын гаргасан 67,791.3 мянган төгрөгийн 4 тушаалыг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.	1	0			1	0		
Дүн	1	0	0	0	1	0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /Төрийн хэмнэлтийн тухай хууль/								
Тайлант онд тээвэр шатахууны зардалд 6,180.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	6180.1						1 6180.1
Байгууллагын даргын 2022.11.23-ны өдрийн Б/59 дүгээр тушаалаар сургуулийн захирал, нягтлан бодогч нарт гар утасны зардал олгосон.	1	120.0	1	120.0				
Дүн	2	6300.1	1	120.0	0	0	1	6180.1
Нийт дүн	3	6,300.1	1	120.0	1	-	1	6180.1

---oOo---